



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

321 дүгээр байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3 гудамж, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101, Утас: (976) 70444469
Цахим шуудан: Sankhuuaudit.bkh.gov.mn
Цахим хаяг: www.sankhuu.bkh.gov.mn

2024.04.03 № 07/05

Баянбулаг сумын төсөвт байгууллагуудын
2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийх

БАТЛАВ
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д. МӨНХСАЙХАН
2024 оны 04 сарын 03-ны өдөр

1. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь "Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх", 8.2.3 дахь "сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна", Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг тус тус үндэслэн хяналт шалгалтыг явуулна.

2. Шалгалтын зорилго

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Захиргааны ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Боловсролын тухай болон бусад хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журам, стандарт, норм нормативын хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдал, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үр өгөөжийг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, ажил хариуцсан албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлэх, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

3. Шалгалтын зарчим, хугацаа, хамрах хүрээ.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн

642307010

төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Баянбулаг сумын төсөвт байгууллагуудын 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” 07/... дугаар удирдамжийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагааг ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалтын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтлан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглүүлж 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 07 хоногт багтаан явуулна. Зайлшгүй шаардлагатай гэж үзвэл байгууллагын удирдлагад мэдэгдэж шалгалтын хугацааг сунгана.

4. Шалгалтын бүрэлдэхүүн

Хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Жаргалцэцэг ахалж, Дотоод аудитор Л.Оюундэлгэр, О.Бямбасүрэн нар хамтран хийж гүйцэтгэнэ.

5. Шалгалтад хамрагдах асуудлууд

5.1.Өмнөх онуудад тус байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын дүн, тогтоосон акт, албан шаардлага, өгсөн үүрэг зөвлөмжийн биелэлт, түүний мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажилтай танилцаж биелэлтийг тооцох.

5.2.Санхүү, төсвийн холбогдолтой хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.

Санхүүгийн хяналт шалгалт нь санхүү, төсөв, эдийн засгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хуулийн холбогдох зүйл ангиар авч үзэж дүгнэлт гаргана.

Шалгагдаж байгаа байгууллагатай холбогдолтой төрийн захиргааны эрх бүхий байгууллагын тушаал, захирамж, зааврын биелэлтийг шалгаж цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулна.

Шалгагдаж буй байгууллагын хөдөлмөрийн гэрээ, дотоод журам болон байгууллага, хүмүүстэй байгуулсан гэрээ, хэлцэл нь санхүү, хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэхийг хянан үзэж санал зөвлөмж гаргана.

5.3.Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт.

Тухайн байгууллагын орлогын төлөвлөгөө, түүний биелэлт.

Төсвөөс санхүүждэг байгууллагад төсвийн зарцуулалтыг зардлын зүйл тус бүрээр судлан шалгаж, тэдгээрийн зарцуулалтыг хууль тогтоомжийн холбогдох заалттай нь нийцүүлэн авч үзнэ.

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан эсэхэд онцгойлон анхаарч, үр ашиг бага зүйлд хөрөнгө мөнгө зарцуулсан байдлыг баримт тооцоогоор баталж, цаашид авах арга хэмжээг боловсруулна.

Ажиллагсдын цалин хөлс (үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс), шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор, хөнгөлөлтийн тогтоолт, олголт, тайлант жилээр цалингийн өглөг, авлагатай эсэх, түүний шалтгаан.

5.4.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалт.

Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон цаг хугацаанд нь хийж тооцоог бодож, үр дүнг шийдвэрлэсэн эсэхийг тооллогын бүртгэл, тооцоо бодсон акттай тулгах.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт, илүүдэл болон ашиглалтгүй, их хэмжээгээр нөөцлөгдсөн хөрөнгө байгаа эсэх, тэдгээрийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх арга замыг тодорхойлох.

Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдсөн эсэх.

5.5.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт үнэн зөв найдвартай байдал.

Тайлан баланс гаргалтын байдал.

Мөнгөн хөрөнгө, бараа материалын баримтын бүрдүүлэлт, өр, авлага, тэдгээрийн үлдэгдлийг үндсэн баримтаар баталгаажуулсан эсэх.

5.6. Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, тусламж, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, үр дүн.

5.7.Байгууллагын удирдлага, нягтлан бодогч, эд хариуцагч, бусад албан хаагчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.

5.8.Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөлт, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.

5.9.Хандивлагч орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа тусламж, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, өгсөн, авсан хандив тусламжийн тайлан тооцоо, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүний үр дүн.

5.10.Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү төсөв, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах талаар зохиосон ажил (тендер), түүний

үр дүн, Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, бусад мэдээллийн хэрэгсэл болон холбогдох сайтуудад мэдээ, тайланг хугацаанд нь байршуулсан эсэх.

5.11.Өглөг, авлагыг данс бүртгэлд үнэн зөв, бүрэн тусгасан эсэх, түүнийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэх, үүссэн шалтгаан, түүний барагдуулалт, найдваргүй авлага, эзэнгүй өглөг үүсгэсэн эсэх, зохих журмын дагуу хаасан эсэх, өглөг авлагыг барагдуулах талаар санаачилж зохион байгуулсан ажлын талаар.

5.12.Нэмэлт орлого, түрээс, туслах аж ахуйн үйл ажиллагаа, түүний орлого, зарлагын гүйцэтгэл, үр дүн, төсвийн бүрэлдэхүүн хэсэгт бүртгэсэн эсэх.

5.13.Шаардлагатай нөхцөлд өмнөх болон дараах хугацааны баримтыг албаны даргад, эсхүл хяналт шалгалтыг ахалж байгаа улсын (ахлах) байцаагчид мэдэгдэж зөвшөөрлөөр шалгалтад хамруулах.

6. Шалгалтын явцад хийх ажлууд

6.1.Шалгалтын удирдамжийг шалгагдаж байгаа байгууллагын удирдлагуудад танилцуулж, шалгалтад хамрагдвал зохих албан тушаалтнуудыг байлцуулан санхүүгийн баримтыг хүлээн авч байгууллагын удирдлага нягтлан бодогч албан тушаалтнуудаар баталгаа гаргуулан шалгалтын хугацаанд шалгагчийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. Баримт хүлээн авснаас хойших баримт бүрдүүлэлтийг шалгалтад хамруулахгүй.

6.2.Шалгалтын явцад шалгаж буй асуудлын талаар байгууллага иргэдийг санал хүсэлт, гомдол, мэдээлэл өгөх боломжоор хангаж, хүлээн авч хууль эрх зүйн актын дагуу шийдвэрлэж хариу өгөх.

6.3.Шалгалтын явцад шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн хүмүүсийг шалгалтад татан оролцуулах асуудлыг албаны даргад тавьж шийдвэрлүүлэх, шалгалтад холбогдолтой материалыг хуулбарлан авч хуулбар үнэн тэмдэг даруулж ажлын баримт бүрдүүлэх, шалгалтад холбогдох асуудлаар амаар болон бичгээр тайлбар тодорхойлолт авч шалгалтын материалд хавсаргана.

6.4.Хяналт шалгалтад шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээллийн дагуу хяналт шалгалтыг албаны дарга, эсхүл ахалж байгаа улсын (ахлах) байцаагчийн зөвшөөрлөөр хийж гүйцэтгэх, албаны дарга, эсхүл ахалж байгаа улсын (ахлах) байцаагчийн өгсөн үүргийн дагуу нэмэлт мэдээллийн хяналт шалгалтыг шалгалтын бүрэлдэхүүн нэмэлт удирдамжгүйгээр хийж гүйцэтгэнэ.

6.5.Шалгагч нь шалгагдагч байгууллагын эдийн засаг, хөрөнгө санхүү,

бүртгэлийн үйл ажиллагааны талаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал, хохиролд шалгалтын танилцуулга, зөвлөмж, акт, албан шаардлага бичиж холбогдох этгээдэд танилцуулан гарын үсэг зуруулж, тамга тэмдэг даруулна.

6.6.Улсын (ахлах) байцаагч, танилцуулга, акт, албан шаардлага зөвлөмж, дурдагдсан зүйл, гаргасан дүгнэлтийг зөвшөөрөөгүй болон татгалзсан тохиолдолд холбогдох хүмүүсээс албан ёсны тайлбар авч хавсарган шалгалтын материалд гарын үсэг зуруулах буюу тэмдэглэл хөтөлж шалгалтын материалд хавсаргана.

6.7.Санхүү, бүртгэл, захиргааны хариуцлага, төрийн хяналт шалгалтын чиглэлээрх хууль, тогтоомж эрхзүйн актуудыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хариуцлага хүлээлгэх асуудлыг уламжилж, шаардлагатай гэж үзвэл удирдах байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж хариу авна.

6.8.Шалгалтаар гэмт хэргийн шинжтэй зөрчил илрүүлсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг танилцуулга, тайланд тодорхой тусган бичих, цааших үйлдлийг зогсоож түүнд холбогдох акт, албан шаардлага, нотлох материалыг хуулийн байгууллагад шилжүүлж аймгийн Дотоод Аудитын хорооны хуралд танилцуулна.

6.9.Танилцуулга, актаар тогтоосон хохирол, нөхөн төлбөр төлөх, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хугацааг хожимдуулсан бол хуулийн байгууллагад нэхэмжлэл гаргах, акт баталгаажуулах, хариуцлага тооцуулахаар уламжлах зэрэг арга хэмжээг авч үр дүнг шалгагч бүрэн тооцсон байна.

6.10.Шалгалтын хугацаанд сонсголын баримт үйлдэн, шалгалтад хамрагдсан удирдлага, албан хаагчдын иргэний үнэмлэхийг канондож шалгалтын материалд хавсаргана. (Акт, шалгалтын танилцуулгад)

6.11.Томилогдсон ажлын хэсэг тухайн байгууллагатай холбогдолтой эрх зүйн актын хүрээнд байгууллагын шууд захирагч, бүртгэл тооцооны болон ажилтан нарт сургалт зохион байгуулна.

7. Үүрэг хариуцлага

7.1.Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага.

7.1.1.Шаардлагатай тайлан мэдээ, санхүүгийн баримт, бусад материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх.

7.1.2.Шалгалтын явцад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах.

7.1.3.Шалгалтын танилцуулгатай танилцаж санал, тайлбар өгөх.

7.1.4.Шалгалтын хугацаанд ажлын бус цагаар ажиллах.

8.Шалгалтын үр дүн, цаашид авах арга хэмжээ

8.1.Шалгалтын үр дүнг байгууллагын хамт олны хуралд танилцуулан санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч хурлын тэмдэглэлийг нэгдсэн материалд хавсаргана.

8.2.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар шалгалтын танилцуулга бичиж, шалгалтын дүнг Албаны болон аймгийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж үр дүнг баталгаажуулж, шийдвэр гаргуулах.

8.3.Хурлын шийдвэрээр баталгаажсан үр дүн, шийдвэр, нэгдсэн танилцуулга, акт, зөвлөмж, албан бичгийг шалгагдагч байгууллагад хүргүүлэх, үр дүнг тооцон ажиллах.

8.4.Шалгалтын дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Дотоод аудитын хороо, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын зөвшөөрлөөр мэдээлнэ. Шалгалтын мэдээг албаны веб хуудсанд байршуулна.

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД АУДИТОР

Л.ОЮУНДЭЛГЭР

ТАНИЛЦСАН:
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ЗАСАГ ДАРГА

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА

ТӨРИЙН САНГИЙН

МЭРГЭЖИЛТЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН

ДАРГА

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

СОЁЛЫН ТӨВИЙН

ЭРХЛЭГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

НЯРАВ

НЯРАВ

НЯРАВ

НЯРАВ

НЯРАВ

НЯРАВ

Р.ЖАМЪЯАНДОРЖ

Ц.ГАНБОЛД

Д.ПҮРЭВСҮРЭН

Д.ЦЭНДАЮУШ

Б.НЯМСҮРЭН

А.ЭРДЭНЭМӨНХ

О.ГАНДИЙМАА

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Л.ЭНХЦЭЦЭГ

С.ПҮРЭВСҮРЭН

Б.ЧИМЭДЦИЕН

С.ГАНБОЛД

Д.ЖАВХЛАН

Ц.АЛТАНГЭРЭЛ

Ч.ЧУЛУУНБАТ

П.ЧАЛХААСҮРЭН

Н.САРУУЛГЭРЭЛ

БАЯСГАЛАНЖАРГАЛ

Ц.ПҮРЭВЖАВ



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН АЛБА
ТАНИЛЦУУЛГА**

321 дүгээр байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70444469
Цахим шуудан: Sankhuuaudit.bkh.gov.mn
Цахим хаяг: www.sankhuu.bkh.gov.mn

2024.04.12 № 08/17

「 БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.ПҮРЭВСҮРЭН, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНД-АЮУШ, НЯГТЛАН
БОДОГЧ Б.ЧИМЭДЦЭЭЭ НАРТ

「 Засаг даргын Тамгын газрын 2022, 2023
он, ОНХСан, ХХСангийн 2023 оны төсвийн
хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад
хяналт шалгалт хийсэн тухай

1.Нийтлэг үндэслэл

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь “Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх”, 8.2.3 дахь “сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг тус тус үндэслэн хяналт шалгалтыг явууллаа.

2.Шалгалтын зорилго.

Хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журам, стандарт, норм нормативын хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдал, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үр өгөөжийг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, ажил хариуцсан албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлэх, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

3.Хяналт шалгалтын хийх үндэслэл, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хамрах хүрээ, хугацаа.

1.Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 03-ны

642407017

өдрийн 07/05 дугаар удирдамжийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд 2022, 2023 оны дансны дэлгэрэнгүй хуулга, санхүүгийн болон бусад тайлан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, удирдлагын гаргасан шийдвэр, мэдээ судалгаа болон бусад баримтууд (дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, ажил гүйцэтгүүлэх гэрээнүүд гэх мэт) хамрагдсан.

2. Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь 2022, 2023 оны санхүү, төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, гүйцэтгэлт хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Жаргалцэцэг, Дотоод аудитор О.Бямбасүрэн нар 2024 оны 04 дүгээр сарын 05-аас 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

3. Тус байгууллага нь Төрийн сангийн 100031655001 тоот харилцах дансаар, нэмэлт санхүүжилтийн 100031655402 тоот дансаар орлого зарлагын гүйлгээ хийж, төсөв хөрөнгийг захиран зарцуулсан, шалгалтад хамрагдсан тайлант хугацааны санхүүгийн баримтад гарын үсгийн нэгдүгээрийг дарга Д.Цэнд-Аюуш (2022.01.01-ээс 2023.12.31-ийг хүртэл), гарын үсгийн хоёрдугаарыг Нягтлан бодогч Ц.Нямдорж (2022.01.01-ээс 2022.12.20), Б.Чимэдцэеэ (2022.12.20-ээс, 2023.12.31) нар зурж төсвийг захиран зарцуулж, эд хариуцагчаар Ч.Чулуунбат(2022.01.01-ээс 2023.12.31-ийг хүртэл) ажилласан байна.

4.Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл:

1.Баянбулаг сумын 1,778 иргэнд хууль тогтоомжийн хэрэгжилт, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газар нь Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын орлогч, багийн дарга-4, Санхүүгийн албаны дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Байгаль орчны Улсын байцаагч, Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, Хууль эрх зүйн дотоод ажлын мэргэжилтэн(Мэдээлэл технологи, оператор хариуцсан ажилтан), Хүнс,

жигжиг дунд үйлдвэр, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежент, малын үржил бүртгэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийтийн биеийн тамирын арга зүйч, нягтлан бодогч-2, нярав, архив, бичиг хэргийн эрхлэгч, жолооч, үйлчлэгч, гэрээт ажилтан-4 нийт 25 орон тоотойгоор үйл ажиллагаагаа, Нийгмийн даатгалын байцаагч, Татварын Байцаагч, Мал эмнэлэг үржлийн тасаг дарга, Улсын бүртгэгч, Хөдөлмөрийн халамжийн сум хариуцсан мэргэжилтэн, Газрын даамал, Байгаль хамгаалагч, Хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулж ажилласан байна.

1. Байгууллагын онцлог ажил:

“Баянбулаг” омог хонийг өсгөн үржүүлэх сурталчлах үүднээс тус сумаас 20 сумд 400 хээлтүүлэгч хурган хуцыг бэлтгэн нийлүүлж ажилласан. Энэхүү ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 400 эм хонь, 2 хуц, 8 хээлтүүлэгчийг хүлээн авч тусгай Малчин томилон уг омгийг өсгөн үржүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж байна.

Баянбулаг сумын түүхт 100 жилийн ойн ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид ойн арга хэмжээнд хэрэглэгдэх цагаан идээг боловсруулж ааруул, цэрэм, өрөм, зөөхий зэргийг өөрсдөө хийж бэлтгэсэн нь томоохон онцлог ажил байна.

5.Өмнөх хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас “Эрсдэлгүй объект-Зөрчилгүй хамт олон” аяны хүрээнд 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, Зөвлөн туслах үйлчилгээний дүнгээр төсөвт байгууллагаас 59.8 оноо авсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2022 онд түүвэрт хамрагдаж 1,232,800 төгрөгийн төлбөрийн акт, 121,434,900 төгрөгийн албан шаардлага, 4,268,000 төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

Төрийн аудитын тайлангийн аудитаар 2023 онд 4,000,000 төгрөгийн төлбөрийн акт, 4,843,800 төгрөгийн зөвлөмж өгч “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан байна.

6.Хяналт шалгалтад хамрагдсан асуудлууд, илэрсэн зөрчил, дутагдлын талаар

6.1.Байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт, түүний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн

Засаг даргын Тамгын газар нь мөнгөн гүйлгээний тайлангаар 2022 онд Орон нутгийн төсвөөс 391,329,300 төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 35,762,008

төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 1,000,000 төгрөг нийт 392,329,300 төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 389,160,817 төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж орон нутгийн төсөвт 14,067,026 төгрөгийн төвлөрүүлж, 2023 онд Орон нутгийн төсвөөс 728,008,300 төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 1,000,000 төгрөг нийт 729,008,300 төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 676,297,649 төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж орон нутгийн төсөвт 38,572,139 төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт-1		(төгрөг)					
№	Үзүүлэлт	2022 он		2023 он		Өөрчлөлт (ТГ)	
		Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл дүнгээр	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	217,248,200	220,872,459	377,252,200	373,809,372	152,936,913	69.2
2	Ажил олгогчоо НДТШ	26,653,700	27,106,600	47,156,600	47,124,594	20,017,994	73.8
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,534,200	24,083,426	30,052,900	27,726,402	3,642,976	15.1
4	Хангамж, бараа материалын зардал	33,592,200	34,017,765	43,695,600	35,668,440	1,650,675	4.9
5	Эд хогшил	2,300,000	2,300,000	12,600,000	12,600,000	10,300,000	447.8
6	Томилолт	2,931,000	2,732,000	9,695,700	6,810,000	4,078,000	149.3
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,773,500	14,685,945	97,824,000	92,198,706	77,512,761	527.8
8	Бараа үйлчилгээний бусад зардал	47,654,300	55,649,180	51,686,000	21,314,835	(34,334,345)	-61.7
9	Бусад урсгал шилжүүлэг	11,655,500	7,713,442	59,045,300	59,045,300	51,331,858	665.5
10	Төвлөрүүлэх зардал	-	14,067,026		38,572,139	24,505,113	174.2
Нийт зарлагын дүн		382,342,600	403,227,843	729,008,300	714,869,788	311,641,945	77.3
1	Орон нутгийн төсвөөс санхүүжих	391,329,300	388,160,617	728,008,300	727,928,300	339,767,683	87.5
2	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000	1,000,000	1,000,000	1,080,000	80,000	8.0
3	Нэмэлт санхүүжилт	-	35,762,008		52,957,763	17,195,755	48.1
Санхүүжүүлэх эх үүсвэр		392,329,300	424,922,625	729,008,300	781,966,063	357,043,438	84.0

Тус байгууллагын 2022 оны зарлагын гүйцэтгэлээс 2023 он нь 287,136,832 төгрөг 73,8 хувиар өссөн нь төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 50%, албан хаагчдын үндсэн цалин Засгийн газрын тогтоолоор нэмэгдсэнтэй холбоотой байна.

6.2. Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт

Засаг даргын Тамгын газар нь албан хаагчдад 2022 онд нийт 230,751,157 төгрөгийн цалинг олгохоор тооцоолж нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгалд, бусад суутгалд нийт 67,061,332 төгрөгийг

суутган 163,689,825 төгрөгийг гарт олгож, 2023 онд 380,163,607 төгрөгийн цалин олгохоор бодогдож, шимтгэл, татвар, бусад суутгалд 137,484,365 төгрөгийг суутгаж, багш, албан хаагчдад 242,679,242 төгрөгийн цалин гарт олгосон байна.

Цалин хөлс

Хүснэгт-2

(төгрөг)

№	Ангилал	2022		2023	
		Нийт дүн	Хувь	Нийт дүн	Хувь
1	2	3	4	5	6
1	Бодогдсон үндсэн цалин	166,229,411	72.0	235,754,257	62.0
2	Онцгой нөхцөлийн нэмэгдэл	15,372,936	6.7	22,026,964	5.8
3	Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл	4,770,249	2.1	6,654,486	1.8
4	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	7,187,129	3.1	14,311,491	3.8
5	Мэргэжлийн зэргийн нэмэгдэл	4,599,365	2.0	8,394,372	2.2
6	Орон нутгийн нэмэгдэл		0.0	27,308,927	7.2
7	Ур чадвар	3,621,824	1.6	4,170,911	1.1
8	Үр дүнгийн урамшуулал	11,145,924	4.8	27,328,316	7.2
9	Ээлжийн амралт	15,563,713	6.7	21,645,064	5.7
10	Төрийн албаны нууц хамгаалах ажилтны нэмэгдэл	2,260,606	1.0	2,745,319	0.7
11	Цалингийн зөрүү	-	0.0	1,143,500	0.3
13	Хоолны хөнгөлөлт, цалингийн зөрүү	-	0.0	8,680,000	2.3
	Нийт дүн	230,751,157	100.0	380,163,607	100.0
1	Нийт суутгал	67,061,332	29.1	137,484,365	36.2
2	Нийт гарт олгох дүн	163,689,825	70.9	242,679,242	63.8

Нийгмийн даатгалын шимтгэл:

Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалтын тайлангаар 2022 онд нийт 230,751,157 төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого мэдээлснээс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 29,244,642 төгрөг, даатгуулагчаас 26,893,221 төгрөг, нийт 56,137,863 төгрөг, мөнгөн гүйлгээгээр 56,144,938 төгрөгийг Нийгмийн даатгалын харилцах дансруу шилжүүлж 7,502 төгрөг илүү шилжүүлсэн. 2023 онд 380,163,607 төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого мэдээлснээс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 47,335,812 төгрөг, даатгуулагчаас 43,517,271 төгрөг, нийт 90,751,233 төгрөг, мөнгөн гүйлгээгээр 90,751,233 төгрөгийг Нийгмийн даатгалын харилцах дансруу шилжүүлж өглөг, авлагагүй ажилласан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт

Хүснэгт-3

(төгрөг)

Сар	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	2022 онд ногдуулсан шимтгэл (төгрөг)			Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	2023 онд ногдуулсан шимтгэл (төгрөг)		
		Нийт дүн	Ажил олгогч	Даатгуулагч		Нийт дүн	Ажил олгогч	Даатгуулагч
1	17,272,254	4,145,347	2,159,036	1,986,311	22,028,816	5,286,915	2,753,602	2,533,313
2	17,426,353	4,182,328	2,178,297	2,004,031	21,972,285	5,248,476	2,734,105	2,514,378
3	18,578,858	4,458,929	2,322,360	2,136,569	21,986,351	5,251,852	2,735,863	2,515,995
4	17,831,223	4,223,936	2,199,969	2,023,967	22,535,175	5,383,570	2,804,461	2,579,109
5	18,221,324	4,373,120	2,277,669	2,095,451	21,852,068	5,219,624	2,719,072	2,500,552
6	17,718,354	4,252,406	2,214,796	2,037,610	24,121,256	5,663,396	3,003,723	2,761,507

1	2	3	4	5	6	7	8	9
7	22,298,448	5,351,627	2,787,306	2,564,321	32,545,860	7,778,006	4,051,734	3,726,274
8	18,298,636	4,391,673	2,287,328	2,104,345	32,378,255	7,737,781	4,030,784	3,706,999
9	17,589,319	4,221,438	2,198,668	2,022,770	38,671,893	9,248,254	4,817,487	4,430,767
10	18,806,150	4,513,477	2,350,770	2,162,707	34,343,076	8,209,338	4,276,385	3,932,954
11	19,909,482	4,778,278	2,488,688	2,289,590	36,968,481	8,839,435	4,604,560	4,234,876
12	24,280,756	5,827,384	3,035,095	2,792,289	70,760,091	16,884,583	8,804,036	8,080,547
	230,751,157	54,719,943	29,244,642	26,893,221	380,163,607	90,751,233	47,335,812	43,517,271

6.3. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт тооцоо бодолт

Байгууллагын өмч хөрөнгийг ашиглаж байгаа албан хаагч бүрээр картжуулж, эзэмшүүлсэн байна. Хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон тооллого хийж илтгэх хуудсаар дүнг гарган нягтлан бодогч тооцоог бодож баталгаажуулсан байна.

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 2023 оны жилийн хагас жилийн эд хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж, цаашид ашиглах боломжгүй 97,844,400 төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах саналыг хэлэлцэж холбогдох байгууллагат санал хүргүүлэн ажилласан байна.

Сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 онд төсвийн хөрөнгөөр 12,298,000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, Сумын ОНХСангийн хөрөнгөөр 18,800,000 төгрөгийн 2 худгийн барилга, 9,645,000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, Аймгийн төрийн сангаас 800,000 төгрөгийн тавилга, 2,700,000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, УИХ-ын гишүүний багц 14,803,100 машин тоног төхөөрөмж, Мал эмнэлэгийн газраас 943,955 төгрөгийн машин тоног төхөөрөмж, Улсын төсвөөс 5,580,00 төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, сумын ОНХСангийн хөрөнгөөр 75,496,276 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 5,280,000 төгрөгийн программ, 34,210,000 төгрөгийн сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нийт 168,258,331 төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч үндсэн хөрөнгө 1,553,793,953 төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2023 онд Төсвийн хөрөнгөөр 20,000,000 төгрөгийн сайжруулалт, 4,344,900 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,350,000 төгрөгийн тавилга, 35,030,000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 64,724,900 төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Сумын ОНХСангийн хөрөнгөөр 112,800,000 төгрөгийн универсал трактор, 121,974,242 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, Улсын төсвөөс 2,790,000 төгрөгийн мотоциколь, 11,084,000 төгрөгийн газар нийт 248,648,242 төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн 72 дугаар тогтоолоор 97,844,400 төгрөгийн моторыг акталж 1,769,322,695 төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө

Хүснэгт-4

(төгрөг)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Акталсан	Эцсийн үлдэгдэл
---	----------	----------------	-----------	----------	-----------------

1	2	3	4	5	6	7
			Төсвийн хөрөнгө	Бусад эх үүсвэр	хөрөнгө	
Үндсэн хөрөнгийн тайлан 2022						
1	Барилга байгууламж	781,556,683	-	18,800,000	-	800,356,683
2	Машин Тоног төхөөрөмж	200,430,456	12,298,000	28,092,055	-	240,820,511
3	Тавилга эд хогшил	51,476,211	-	800,000	-	52,276,211
4	Авто тээврийн хэрэгсэл	174,534,800	-	5,580,000	-	180,114,800
5	Бусад үндсэн хөрөнгө	155,903,273	-	75,496,276	-	231,399,549
6	Программ хангамж	230,000	-	5,280,000	-	5,510,000
7	Бусад биет бус хөрөнгө	9,106,200	-	34,210,000	-	43,316,200
Дүн		1,373,237,623	12,298,000	168,258,331	-	1,553,793,954
Үндсэн хөрөнгийн тайлан 2023						
1	Барилга байгууламж	800,356,683	20,000,000	-		820,356,683
2	Машин Тоног төхөөрөмж	240,820,511	4,344,900	-	97,844,400	147,321,011
3	Тавилга эд хогшил	52,276,211	5,350,000	-	-	57,626,211
4	Авто тээврийн хэрэгсэл	180,114,800		115,590,000	-	295,704,800
5	Бусад үндсэн хөрөнгө	231,399,549	35,030,000	121,974,242	-	388,403,791
6	Программ хангамж	5,510,000	-	-	-	5,510,000
7	Бусад биет бус хөрөнгө	43,316,200	-	11,084,000	-	54,400,200
Дүн		1,553,793,954	64,724,900	248,648,242	97,844,400	1,769,322,696

Бараа материалын тайлангаар 2022 онд төсвийн хөрөнгөөр нийт 97,889,875 төгрөгийн бараа материал худалдан авч, 29,856,450 төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 86,985,125 төгрөгийн материалыг зарцуулж, 79,916,033 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Төсвийн хөрөнгөөр 2023 онд 102,944,838 төгрөгийн материалыг худалдан авч, 163,754,344 төгрөгийн материалыг шилжүүлэн авч үйл ажиллагаанд 160,797,223 төгрөгийн материал зарцуулж, 185,817,992 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Бараа материал

Хүснэгт-5

(төгрөг)

№	Үзүүлэлт	2022 он				
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Шилжүүлэн авсан	Зарцуулсан	
1	2	3	4	5	6	7
1	Тусгай зориулалтын материал	12,561,525.00	34,060,000.00	20,378,950.00	12,977,250.00	54,023,225.00
2	Сэлбэг хэрэгсэл	310,000.00	4,520,500.00	-	4,520,500.00	310,000.00
3	Бичиг хэргийн материал	100,000.00	6,474,800.00	-	5,614,800.00	960,000.00
4	Аж ахуйн материал	7,077,280.00	5,285,500.00	9,477,500.00	14,270,500.00	7,569,780.00
5	Түлш, шатах тослох материал	3,080,500.00	39,298,375.00	-	42,378,875.00	-
6	Хүнсний материал	220,000.00	5,935,200.00	-	6,155,200.00	-
7	Бусад хангамж	15,805,528.03	2,315,500.00	-	1,068,000.00	17,053,028.03

1	2	3	4	5	6	7
Нийт дүн		39,154,833.03	97,889,875.00	29,856,450.00	86,985,125.00	79,916,033.03
2023 он						
1	Тусгай зориулалтын материал	54,023,225.00	34,300,000.00	161,604,711.00	98,883,450.00	151,044,486.00
2	Эм боох материал	-	-	2,000,000.00	2,000,000.00	-
3	Бичиг хэргийн материал	960,000.00	6,445,830.00	-	6,703,100.00	702,730.00
4	Аж ахуйн материал	7,569,780.00	3,960,500.00	-	4,673,000.00	6,857,280.00
5	Түлш, шатах тослох материал	-	34,337,909.00	-	34,337,909.00	-
6	Хүнсний материал	-	11,935,099.00	-	8,735,099.00	3,200,000.00
7	Сэлбэг хэрэгсэл	310,000.00	3,227,500.00	-	813,500.00	2,724,000.00
8	Бусад хангамж	17,053,028.00	8,738,000.00	149,633.25	4,651,165.00	21,289,496.25
Нийт дүн		79,916,033.00	102,944,838.00	163,754,344.25	160,797,223.00	185,817,992.25

6.4.Өр авлагын байдал, өссөн буурсан шалтгааныг тодруулж барагдуулалт, найдваргүй авлага, эзэнгүй өглөгийн талаар

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайлангаар 2022 онд ажилчидтай холбоотой авлага 425,229 төгрөг, 1,865,476 төгрөгийн өглөг үүсгэж, 2023 онд 10,000,000 төгрөгийн өглөгтэй, татан төвлөрүүлэлтийн авлага 15,107,904 төгрөгийн авлагатай ажилласан байна.

Өглөг авлагын дэлгэрэнгүй

Хүснэгт-6

(төгрөг)

№	Төрөл	2022 онд үүссэн өглөг, авлага				
		Эхний үлдэгдэл		Нэмэгдсэн	Хорогдсон	Үлдэгдэл
		Өглөг	Авлага			
1	2	3	4	5	6	7
1	Ажиллагчидтай холбогдсон өглөг	474	-	303,783,883	302,035,681	1,748,676
2	Байгууллагат төлөх өглөг		-	94,657,830	94,541,030	116,800
Өглөгийн дүн		474	0	398,441,713	396,576,711	1,865,476
1	Ажиллагчидтай холбогдсон авлага			425,229.24	-	425,229.24
2	Байгууллагаас авах авлага	-	1,470,810	-	1,470,810	-
Авлагын дүн		-	1,470,810	425,229	1,470,810	425,229
2023 онд						
1	Ажиллагчидтай холбогдсон өглөг	1,748,676	-	503,324,646	505,073,322	-
2	Байгууллагат төлөх өглөг	116,800	-	306,282,049	296,398,849	10,000,000
Өглөгийн дүн		1,865,476	-	809,606,695	801,472,171	10,000,000
1	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	425,229	16,152,805	1,470,130	15,107,904
Авлагын дүн		-	425,229	16,152,805	1,470,130	15,107,904

6.5.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт:

1.Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тооцоолох, ТАЦНсистем, ашигладаг бөгөөд 2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн

тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн бодит байдалд 2022 онд түүвэрт хамрагдаж, 2023 онд Төрийн аудит дүгнэлт өгсөн байна.

2. Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, байгууллагын хөрөнгө мөнгөнд бүртгэлээр тавих хяналт хэвийн явагдсан, НББ-ийн "Acolous" программаар бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийг гаргасан, Төсвийн байгууллагын Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр цалинг бүрэн тооцоолж бодож хэвшсэн, Санхүү төрийн сангийн хэлтэст төсвийн гүйцэтгэлийн тайлан, сар бүрийн мэдээг хугацаанд нь гаргасан, 2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хэлбэрээр байршуулсан, НДШ-ийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг сар, улирал тутамд цахимаар илгээж, цаасаар баталгаажуулсан байна.

6.6. Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт зарцуулалт, үр дүн, Засгийн газрын зээл, тусламж, эргэн төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, үр дүн:

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2022 онд Аймгийн Засаг даргын Тамгын газраас өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой улсын нөөцөөс ирсэн өвс, тэжээлийн тээврийн зардал 7,570,500 төгрөг, малын гоц халдвараас урьдчилан сэргийлэх зардал 1,161,000 төгрөг, Чандмань Баянхонгор ХК-аас ундны усны хөнгөлөлтөд 2,494,000 төгрөг, тендерийн баримт бичгийн зардал 210,000 төгрөг, Хөдөө аж ахуйн туршилтын судалгааны зардал 1,105,800 төгрөг, Аймгийн Засаг даргын Тамгын газраас Сайдын багцийн санхүүжилт 5,000,000 төгрөг, өвсний үнэ 6,611,750 төгрөг, өмнөх оны санхүүжилт 9,608,958 төгрөг, нийт 33,762,008 төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 26,522,506 төгрөгийг зарцуулж 9,239,502 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан бол 2023 онд 35,860,000 төгрөгийн өвс тэжээл, 535,325 төгрөгийн мал тооллогын зардал, 4,000,000 төгрөгийн оготно устгалын зардал, 560,000 төгрөгийн тендерийн баримт бичгийн зардал, 837,936 төгрөгийн малчдын зөвлөгөөний шатахууны зардал, 1,925,000 төгрөгийн бусад эх үүсвэрээс, 9,239,502 төгрөгийн оны эхний үлдэгдэл нийт 51,032,763 төгрөгийн эх үүсвэрээс 35,924,859 төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж 15,107,904 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

6.7. Шалгагдаж байгаа байгууллагатай холбогдолтой төрийн захиргааны эрх бүхий байгууллагын тушаал, захирамж, зааврын биелэлт, байгууллагын хөдөлмөрийн хамтын гэрээ, дотоод журам болон байгууллага, хүмүүстэй

байгуулсан гэрээ, хэлцэл нь санхүү, хууль, эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь 2022 онд үйл ажиллагааны чиглэлээр 32 ширхэг тушаал, хүний нөөцийн чиглэлээр 13 ширхэг тушаал, нийт 45 ширхэг тушаал, 2023 онд хүний нөөцийн чиглэлээр 10, үйл ажиллагааны чиглэлээр 55 тушаал нийт 65 ширхэг тушаалыг шийдвэрлэж ажилласан байна.

2. Сумын Засаг дарга нь 2022 онд хүний нөөц, үйл ажиллагааны чиглэлээр 127 захирамж, 2022 онд хүний нөөц, үйл ажиллагааны чиглэлээр 112 захирамж гаргаж ажилласан байна.

3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай, Нягтлан бодогч бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрмүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилласан байна.

Засаг даргын Тамгын газар хөдөлмөрийн дотоод журмыг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хамт олны олны хурлаар хэлэлцэн баталсан боловч байгууллагын даргын тушаалаар батлаагүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122.1-т “Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ”, 122.2-т “Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмыг шинээр баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах үүрэгтэй”, 122.3-т “Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болон хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заана” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

4. Хамтын гэрээг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн гаргасан боловч Аймгийн Хөдөлмөрийн халамж үйлчилгээний газарт бүртгүүлж үйл ажиллагаандаа мөрдөж ажлаагүй байгаа нь хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг энэ хуулийн 18, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу байгуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

5. Бодлогын барит бичиг, хууль тогтоомж, тогтоолын шийдвэр хэрэгжилт аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2022 оны жилийн эцсийн үнэлгээгээр 70,01%-тай үнэлэгдсэн байна.

6.8.Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөлт биелэлт үр дүнг үнэлж дүгнэх.

1.Сумын Засаг даргын Тамгын газар нь Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулдаггүй байгаа нь Засгийн Газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-н

өдөр баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.5-т Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухай байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 2.3-т “Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино”, 3.7.1-т “зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

6.9.Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.

Тайлант онуудад ажилласан нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан 13 төрлийн эрх, үүргээс 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөр тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ч баримтын иж бүрдэл сайн, нягтлан бодох бүртгэлийн стандартыг чанд мөрдөн ажилласан байна.

6.10.Байгууллагын ил тод байдал хангасан эсэх, шилэн дансны хэрэгжилт

Тус байгууллага нь 2023 онд нийт 159 мэдээллийг байршуулахаас хугацаандаа 154 мэдээлэл, 4 мэдээллийг хугацаа хоцроож, хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

Шилэн дансны мэдээлэл

Хүснэгт-7

(төгрөг)

№	Он	Байгууллага	Хугацаандаа	Хугацаа хоцорсон	Хугацаа болоогүй	Нийт	Хувь
1	2023	ЗДТГазар	154	4	1	159	0,97%
Нийт дүн			154	4	1	159	0.97%

Хяналт шалгалтын хугацаанд төсөвт байгууллагууд дээр санал хүсэлтийг хайрцаг ажиллуулсан ба санал, асуулга орж ирээгүй.

6.11.Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр

Хүснэгт-8

(төгрөг)

Дансны үлдэгдэл	Орлогын эх үүсвэр							Зарцуулалт		Дансны эцсийн үлдэгдэл
	Малын тоо толгойн албан татварын орлого	Тогтвортой амьжиргаа 3 төсөл	Санхүүжилт	Аймгийн ОНХСангийн санхүүжилт эрх шилжүүлэлт	Малжуулах	ХАА	Өвс	Төвлөрүүлэлт	Олгосон санхүүжилт	
71,857,610	32,881,280	37,385,400	220,170,720	90,000,000	4,500,000	715,500	22,186,950	9,080,910	317,242,960	153,373,590

Баянбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны дансны эхний үлдэгдэл 71,587,610 төгрөг, санхүүгийн дэмжлэг 220,170,720 төгрөг, тогтвортой

амьжиргаа 3 төслөөс 37,385,400 төгрөг, малын хөлийн татварын орлого 32,881,280 төгрөг, малжуулах 4,500,000 төгрөг, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжүүлсэн санхүүжилт 90,000,000 төгрөг, өвс тэжээлийн орлого 22,186,950 төгрөг, хөдөө аж ахуйн газраас огтоно устгалын дэмжлэг 715,500 төгрөг, нийт 407,839,850 төгрөгийн эх үүсвэртэйгээр 317,242,960 төгрөгийн төсөл хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, 9,080,910 төгрөг төвлөрүүлэн 153,373,590 төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Баянбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 10 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “2023 оны төсөв батлах тухай” 10/04 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг 302,945,700 төгрөгийн төсөв баталж, 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит 12 дугаар хуралдааны 12/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 62,131,400 төгрөгийн нэмж буюу төсвийн өөрчлөлт оруулж тус тус баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
хийж хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зарцуулалт

Хүснэгт-9

(төгрөг)

№	Баталсан хөрөнгө оруулалт	Баталсан мөнгөн дүн	Нэмж Тодотгосон	Аймгийн ОНХСангийн дэмжлэг	Зарцуулалтын гүйцэтгэлийн мөнгөн дүн
1	Баянбулаг омгийн цөм сүрэг байгуулах,	20,000,000			9,199,250
2	Тэр бум мод тарих	20,000,000			19,400,000
3	Гудамжны гэрэлтүүлэг	40,000,000		50,000,000	90,000,000
4	Сумын баяр наадам	5,000,000			5,000,000
5	Нохой устгал хийх	5,000,000	5,000,000		2,500,000
6	Универсаль тролктор	130,000,000			112,800,000
7	Хангал төшингийн даваа засвар	8,000,000			7,920,000
8	Хавар намрын мал ангилалт	9,945,700	4,436,600		7,948,300
9	Халуун ус	-	40,338,300	-	40,000,000
10	Оготно устгал	9,000,000	5,000,000		8,897,810
11	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	6,000,000	7,356,500		217,600
12	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	19,000,000			13,360,000
13	Жи мобайлийн антенн суурьлуулах	30,000,000			-
Нийт дүн		301,945,700	62,131,400	50,000,000	317,242,960

Малын тоо толгойн албан татварын 2023 онд 28,000,000 төгрөгийн орлого төлөвлөж, гүйцэтгэлээр 32,881,280 төгрөг төвлөрүүлж, 13,6 хувиар давуулсан байна.

6.12.Хоршоо хөгжүүлэх сан

Баянбулаг сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа

Хүснэгт 10

(төгрөг)

№	Он	Санхүүжилт	Орлого			Зарлага			Харилцах дансны үлдэгдэл	Зээл, зээлийн хүүгийн авлага				
			Зээлийн эргэн төлөлт	Зээлийн хүү	Нийт дүн	Төслийн тоо	Олгосон зээл	Үйл ажиллагааны зардалд зарцуулсан зардал		Зээл	Зээлийн хүү	Алданги	Нийт дүн	
1	2011	50,000,000		2,260,099	2,260,099	5	50,000,000	-	2,260,099	-	-	-	-	-
2	2012	50,000,000	11,071,968	-	11,071,968	1	5,500,000	260,000	57,572,067	-	-	-	-	-
3	2013	50,000,000	20,712,887	319,418	21,062,305	25	112,500,000	-	16,134,372	5,000,000	43,491	-	-	5,043,491
4	2014	17,060,000	53,885,486	653,059	54,538,545	6	29,000,000	61,850	58,671,067	-	-	-	-	-
5	2015	-	15,154,650	732,819	15,887,469	10	66,148,000	-	8,410,536	-	-	-	-	-
6	2016	-	29,312,474	882,819	30,195,293	5	24,588,300	600,000	13,407,529	11,713,287	-	-	-	11,713,287
7	2017	-	52,827,032	1,417,656	54,244,688	6	50,000,000	1,100,000	16,552,217	-	-	-	-	-
8	2018	-	56,523,134	3,019,939	59,543,073	2	12,000,000	900,000	63,195,290	-	-	-	-	-
9	2019	-	41,299,679	5,690,060	46,989,739	6	60,000,000	490,000	49,695,029	4,728,885	45,945	974,614	5,749,444	-
10	2020	-	69,018,841	5,432,261	74,451,102	16	111,000,000	218,000	12,928,131	54,075,760	920,782	2,714,712	57,711,254	-
11	2021	-	65,770,180	7,767,223	73,537,403	-	-	440,000	86,025,534	-	-	-	-	-
12	2022	-	38,484,649	5,867,912	44,352,561	3	100,000,000	801,001	29,939,094	100,000,000	7,275,764	-	107,275,764	-
13	2023	-	70,937,146	5,915,561	76,852,707	1	43,000,000	649,900	63,141,901	148,547,214	7,604,948	1,559,268	157,711,430	-
14	2024.04.08	-	12,965,095	992,074	13,957,169	-	-	150,000	76,949,069	138,285,233	7,101,294	2,126,039	147,512,566	-
Дүн		167,060,000	537,963,221	40,950,900	565,348,952	86	663,746,300	5,670,751	554,881,935	462,350,379	22,992,224	7,374,633	492,717,236	-

Хоршоо хөгжүүлэх(сум хөгжүүлэх) сангийн хөрөнгөөс 2011 оноос 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар нийт 86 төсөлд 663,746,300 төгрөгийн зээл олгож, зээл зээлийн хүүгийн эргэн төлөлт 565,348,952 төгрөг төвлөрүүлсэн байна. Тус сангийн дансны үлдэгдэл 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 76,949,069 төгрөг, авлага 147,512,566 төгрөг байна.

Хугацаа хэтэрсэн 22,150,123 төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 10/19-01/17 дугаар бүхий Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар төлүүлэх үлдэгдлээс 5,801,755 төгрөгийг барагдуулсан боловч 16,348,368 төгрөгийг барагдуулаагүйд хяналт шалгалтын хугацаанд холбогдох зээлдэгч нарт мэдэгдэл хүргүүлж ажиллалаа.

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү

Хүснэгт 11

(төгрөг)

№	Зээлдэгчийн нэр	Анх авсан зээл		Хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй зээлийн дүн	Үүнээс			Хугацаа хэтэрсэн зээлээс		
		Огноо	Зээлийн дүн		Зээлд	Хүүд	Алданги	Шүүх ба ШШГ дээр	Ямар нэг арга хэмжээ аваагүй төлөгдөөгүй зээлийн дүн	
1	О Онцгэрэл	2013.05.15	5,000,000	5,043,491	5,000,000	43,491		5,043,491	ШШГ	
2	Б.Отгонсүрэн	2020.05.25	10,000,000	6,531,819	5,764,976	55,096	711,747			6,531,819
3	З.Болортуяа	2020.12.14	9,000,000	7,571,922	6,550,639	173,762	847,521			
4	Хөдөө нуурын хаялага	2022.06.29	25,000,000	3,244,815	2,731,326	-	513,489			2,244,627
Нийт дүн			49,000,000	22,392,047	20,046,941	272,349	2,072,757	5,043,491	-	8,776,446

Зээлдэгчийн зээл төлөлт, авлагын үлдэгдэл (2024.04.08)

Хүснэгт 12

(төгрөг)

№	Зээлдэгчийн нэр	Төлбөл зохих дүн	Үүнээс			Эхний үлдэгдэл	Төлсөн дүн	Үүнээс			2024.04.08-ны авлага		
			Зээл	Хүү	Нэмсэн			Зээлд	Хүүд	Алданги	Зээлд	Хүүд	Алданги
1	Онцгэрэл О	5,294,991.0	5,000,000.0	294,991.0	-	5,043,491.0	-	-	-	-	5,043,491.0	5,000,000.0	43,491.0
2	Гүрбазар Б	11,932,032.0	10,000,000.0	542,816.0	1,389,216.0	963,440.0	-	-	-	-	963,440.0	963,440.0	-
3	Хөдөө нуурын хаялага	27,776,235.0	25,000,000.0	2,093,840.0	682,395.0	22,203,665.0	3,752,816.0	3,193,322.0	46,005.0	513,489.0	18,450,849.0	17,592,591.0	858,258.0
4	Дээд өндөр улаан	37,954,856.0	35,000,000.0	2,935,364.0	19,492.0	27,276,924.0	-	-	-	-	27,276,924.0	25,946,125.0	1,330,799.0
5	Таван буур	43,683,898.0	40,000,000.0	3,352,451.0	331,447.0	36,076,977.0	-	-	-	-	36,076,977.0	34,159,900.0	1,917,077.0
6	Дэлгэрэх түмэн сувд	46,599,764.0	43,000,000.0	3,599,764.0	-	42,353,016.0	-	-	-	-	42,353,016.0	39,712,081.0	2,640,935.0
7	Отгонсүрэн Б	11,546,819.0	10,000,000.0	544,075.0	1,002,744.0	6,531,819.0	-	-	-	-	6,531,819.0	5,764,976.0	55,096.0
8	Болортуяа З	10,364,562.0	9,000,000.0	483,611.0	880,951.0	7,571,922.0	-	-	-	-	7,571,922.0	6,550,639.0	173,762.0
Нийт дүн		485,756,105.0	449,497,500.0	28,154,575.0	8,104,030.0	148,020,566.0	3,752,816.0	3,193,322.0	46,005.0	513,489.0	144,267,750.0	135,553,906.0	7,101,294.0

Баянбулаг сумын Хоршоо хөгжүүлэх (сум хөгжүүлэх) сангийн 8 зээлдэгчдээс нийт 144,267,750 төгрөгийн авлагаар бүртгэж ажиллаж, өмнөх хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн сайн тал байна.

6.13.Өвс тэжээлийн талаар:

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын Газрын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтийг 2022 онд 34,192,950 төгрөг, 2023 онд 32,360,000 төгрөгийн төсвийн хөрөнгөөр бэлдэж, өвс тэжээл борлуулсан Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2022 онд 6,611,750 төгрөг, 2023 онд 35,860,000 төгрөг, нийт 42,471,750 төгрөг, 2023 онд ОНХСангийн дансанд 12,258,950 төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт

Хүснэгт 13

(төгрөг)

Он	Баталсан төсөв		Зарцуулсан төсөв		Төвлөрүүлсэн нь	
	Биотехникийн зардал	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт	Биотехникийн зардал (үнэ төлбөргүй нь орсон)	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлсэн нь	ЗДТГ-нэмэлт	ОНХСан
2022	-	20,000,000	3,986,000	34,192,950	6,611,750	-
2023	19,000,000	19,000,000	44,132,000	32,360,000	35,860,000	12,258,950
ДҮН	19,000,000	39,000,000	48,118,000	66,552,950	42,471,750	12,258,950

Засгийн газрын болон улсын онцгой комиссын шийдвэрээр өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сумдад олгосон өвс тэжээл бараа материал, бусад хандив тусламжийг 2022-2023 оны хугацаанд зарцуулсан өвс тэжээлийн бүртгэл тооцоог бодоход дараах байдалтай байна.

Өвс тэжээлийн тооцоо бодолт

Хүснэгт 14

(төгрөг)

Он	Эхний үлдэгдэл	Орлого		Зарлага			Эцсийн үлдэгдэл	Банкинд тушаасан нь		Зөрүү +дутагдал
		Үнэгүй ба биотехник	Борлуулах	Үнэгүй ба биотехник	Борлуулсан	Акталсан		ЗДТГ-нэмэлт	ОНХСан	
2022	12,380,750	3,986,000	34,192,950	5,000,000	6,977,250	-	38,582,450	6,611,750	-	365,500
2023	38,582,450	44,132,000	32,360,000	46,072,000	48,114,950	4,196,500	16,691,000	35,860,000	12,258,950	(4,000)
ДҮН		48,118,000	66,552,950	51,072,000	55,092,200	4,196,500	55,273,450	42,471,750	12,258,950	361,500

Тухайн байгууллагын өвс, тэжээлийн орлого, зарлагын тооцоо бодоход 361,500 төгрөгийн дутагдал илэрч, 2024 оны 04 дүгээр сарын байдлаар өвс тэжээлийг замбараагүй хураасан, тайлан гаргаагүй, сумын онцгой комиссын шийдвэргүй (сумын Орлогч дарга Дархан хотод албан томилолтоор ажиллаж байсан), цаг хүндэрсэнтэй холбоотойгоор ард иргэдэд зээлээр өвс тэжээлийг олгосон тул тооцоог бодоогүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 479 дугаар тогтоол, 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 63 дугаар тогтоолоор

өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сумдад улсын нөөцөөс орон нутаг дахь салбар улсын нөөцөөс өвс тэжээл, бараа материалын үнэгүй олгох, хөнгөлөлттэй үнээр борлуулах хуваарийн дагуу аймгийн Засаг даргын захирамж болон аймгийн Онцгой комисс чиглэлийн хүрээнд сумдад хувиарласан байна. Уг хувиарласан өвс тэжээл, бараа материалын үнэгүй олгох, хөнгөлөлттэй үнээр борлуулахдаа сумын онцгой комисс ажилласан тайлан материал дутмаг байна.

Цаашид 2024 оны өвс тэжээл, бараа материалын үнэгүй олгох, хөнгөлөлттэй үнээр борлуулах хуваарийн дагуу тухай бүр тайлан тооцоог бодож хэвшихийг анхаарах хэрэгтэй байна.

6.14.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:

Засаг даргын нөөц хөрөнгө:

1. Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/64 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын хүүхдүүдийг хүлээн авах хүндэтгэл үзүүлэх, бэлэг гардуулахад 1,000,000 төгрөг зарцуулсан.

2. Байгууллага бүрийн цалингийн зардлын 0,5 хувийг жил бүр Ахмадын сангийн дансанд татан төвлөрүүлдэг байтал Засаг даргын нөөц хөрөнгөнөөс сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг гардуулах зардалд 2022 онд 1,700,000 төгрөг, 2023 онд 5,800,000 төгрөг нийт 7,500,000 төгрөг зарцуулснаас Төрийн аудит 4,000,000 төгрөгт төлбөрий акт тогтоосон байна.

Ахмадуудад олгосон зардлын тооцоо

Хүснэгт-8

(төгрөг)

№	Огноо	Харилцагч байгууллага	Зарцуулалт	Эх үүсвэр	Мөнгөн дүн	Шийдвэр
1	2022	П.Чимэдочир	Ахмадуудыг хүлээн авах хүндэтгэл үзүүлэх	Засаг даргын нөөц	700,000	Сумын Засаг даргын 2022.09.27-ны өдрийн А/101 Захирамж
2		Ч.Мөнхсайхан	Ахмадын бэлэгний үнэ	Засаг даргын нөөц	1,000,000	Сумын Засаг даргын 2022.12.16-ны өдрийн А/122 Захирамж
3	2023	Ч.Чулуунбат	Ахмадуудыг хүлээн авах хүндэтгэл үзүүлэх	Засаг даргын нөөц	1,800,000	Сумын Засаг даргын 2023.09.28-ны өдрийн А/75 Захирамж
4		Ч.Чулуунбат	Ахмадын бэлэгний үнэ	Засаг даргын нөөц	4,000,000	Сумын Засаг даргын 2023.12.20-ны өдрийн А/106 Захирамж(Төрийн аудитын төлбөрийн акттай)
	Нийт дүн				7,500,000	

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн.(Зөвлөмж өгөв.)

3. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Засаг даргын захирамжгүй 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн мөнгөн гүйлгээгээр Э.Эрдэнэбаатар(ЧЖ83041011)-аас 2,145,000 төгрөгийн гүний худгийн ус зөөлрүүлэгч төхөөрөмж худалдаж авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сангийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4-т “Нөөц хөрөнгийг зарцуулалт”, 4.1-т “Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. (Зөвлөмж өгөв.)

4. Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/88 дугаар захирамжаар нутгийн зөвлөлийн уулзалт хэлэлцүүлэгт 5,440,000 төгрөг зарцуулахдаа 3,366,990 төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” Сангийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3-т “Нөөц хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргахад тавигдах шаардлага” 3.1.4-т “арга хэмжээг хэрэгжүүлэхэд

шаардагдах хөрөнгийн хэмжээг зөв, бодитой тооцсон эсэхийг холбогдох норм, норматив, тариф, бусад баримтаар нотолсон байх”, 5-т “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, зардлыг санхүүжүүлэх”, 5.2-т “Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн. (Улсын ахлах байцаагчийн төлбөрийн акт тогтоов.)

Үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил:

1.Баянхонгор аймгийн түүхт 80,81 жилийн ойн үйл ажиллагаанд оролцоход 3,310,000 төгрөгийн зардал зарцуулсан.

Зардлын тооцоолол

Хүснэгт-9

(төгрөг)

№	Харилцагч байгууллага	Зарцуулалт	Эх үүсвэр	Мөнгөн дүн	Шийдвэр
1	Ч.Мөнхсайхан	Айрагны үнэ	Засаг даргын нөөц	1,000,000	Сумын Засаг даргын 2022.07.25-ны өдрийн А/84 Захирамж
2	Ч.Мөнхсайхан	Гэрийн түрээс	ЗДТГ(210801)	500,000	Шийдвэргүй
3	Ч.Мөнхсайхан	Барааны үнэ	ЗДТГ(210801)	810,000	Шийдвэргүй
4	Б.Болд	Хонины мах	ЗДТГ(210801)	1,000,000	Шийдвэргүй
Нийт дүн				3,310,000	

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн.(Зөвлөмж өгөв.)

2.Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн “Хөв цөөрөм байгуулах тухай” А/13 дугаар тушаалаар 19,500,000 төгрөг зарцуулахдаа ямар ажлыг, ямар материалаар хийхийг ажлын гэрээний хавсралтаар тусгаагүй байхад зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.39-т “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч” гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18-т “техникийн тодорхойлолт” гэж худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлага, даалгаврыг тодорхойлсон бүрдүүлбэрийг, 11 дүгээр

зүйлийн 11.2-т “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”, 39 дүгээр зүйлийн 39.3-т “Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана”, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ”, 351.1-т “Захиалагч дараахь үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй. (Зөвлөмж өгөв.)

3.Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/15 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газрын ажилчдын хүүхдүүдэд 1,000,000 төгрөгийн бэлэг худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчсөн. (Зөвлөмж өгөв.)

4.Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/25 дугаар тушаалаар багийн баяр наадам, өдөрлөгийн үйл ажиллагаанд 2,000,000 төгрөг зарцуулсан.

5.Засаг даргын Тамгын газар нь биеийн тамир, спортын арга хэмжээнд 2023 онд нийт 3,356,800 төгрөг зарцуулсан байна.

Биеийн тамир уралдаан тэмцээний шагнал

Хүснэгт-10

(төгрөг)

№	Огноо	Харилцагч байгууллага	Зарцуулалт	Эх үүсвэр	Мөнгөн дүн	Шийдвэр
1	2023	Л.Баяраа	Хангайн бүсийн жудо бөхийн тэмцээнд оролцох	80305/210901	700,000	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023.03.27-ны өдрийн А/08-р тушаал
2		Л.Баяраа	Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох	80305/210901	200,000	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023.05.29-ний өдрийн А/18-р тушаал
1	2	3	4	5	6	7
3	2023	Ч.Чулуунбат	Байгууллага сурталчлах 7 хоног	80305/210901	730,000	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023.12.01-ний өдрийн А/43-р тушаал
4		Т.Дагвадорж	Байгууллага сурталчлах 7 хоног	80101/210901	466,800	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023.11.28-ны өдрийн А/42-р тушаал
5		А.Азбаяр	Оны аварга шалгаруулах тэмцээн	80305/210901	660,000	Сумын Засаг даргын 2023.12.21-ний өдрийн А/53-р тушаал
6		Нэмхонгор ХХК	Оны аварга шалгаруулах тэмцээн	80305/210901	600,000	
	Нийт дүн				3,356,800	

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан

төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн. (Зөвлөмж өгөв.)

6.Баянбулаг сумын Засаг дарга Д.Пүрэвсүрэн, Баянбулаг сумын 2 дугаар багийн М.Бат-Очир нарын хооронд байгуулсан “Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар эко оо барих” ажлын гэрээний дагуу тус ажил 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр бүрэн хүлээлгэж өгөхөөр гэрээнд тусгагдсан байтал тухайн ажил хийгдээгүй байхад Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Эко ариун цэврийн байгууламжийн тухай” А/41 дүгээр тушаалаар 20,000,000 төгрөгийн санхүүжилтийг 100 хувь шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана”, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ”, 351.1-т “Захиалагч дараахь үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажлаагүй байна.(Улсын ахлах байцаагчийн албан шаардлага өгөв.)

7.Бичиг хэргийн зардлаас 2,600,000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 700,000 төгрөг нийт 3,300,000 төгрөгөөр принтер, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 800,000 төгрөгийн ширээ сандал нийт 4,100,000 төгрөг эдийн засгийн ангилал зөрүүтэй зардлаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна. (Зөвлөмж өгөв.)

8.Шатахууны тайлангаар 2023 онд 34,337,909 төгрөгийн зарлага гарсныг хяналт шалгалтаар жолоочийн тооцооны замын хуудастай тулган шалгахад 884,390 төгрөгийн замын хуудас бичигдээгүй, шатахуун зарцуулсан.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13 дугаар зүйлийн 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн,

зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйл “Нягтлан бодох бүртгэл хөтлөх”, 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх” 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”, 20.1.1-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6 дугаар зүйлийн 6.4-т “Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана” гэсэн заалтыг зөрчсөн байна.(Зөвлөмж өгөв)

9.Албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 278,492 төгрөг илүү олгосон.

Илүү олгосон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл

Хүснэгт- 11

(төгрөг)

№	Овог	Нэр	Олго-сон сар	Алба хаасан хугацааны нэмэгдэл				Зөрүү
				Бодогдох хувь	Мөнгөн дүн	Бодогдсон хувь	Мөнгөн дүн	
1	Доржпүрэв	Борхүү	12	5	551,629	8	775,121	223,492
2	Баатар	Батцэцэг	5	6	330,000	7	385,000	55,000
Нийт олгосон дүн								278,492

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 1-т “Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө”, 2-т “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын

сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно”, 5-т “Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн байгууллагын төсвийн шууд захирагчийн тушаалаар энэ журмын 2-т заасны дагуу нэмэгдэл олгох хувийг тогтооно” гэсэн заалтыг зөрчсөн.(Зөвлөмж өгөв.)

Орон нутгийн хөгжлийн сан

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд 2,3 багийн Хангал төшингийн даваа засварын ажилд нийт 7,920,000 төгрөгийн төсөвт баталснаар Таван буур, Баян бумба хоршоонуудтай гэрээ байгуулж тус тус 3,960,000 төгрөгийн төсөв 100 хувийн санхүүжилтийг шилжүүлсэн боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, цаг үеийн нөхцөл хүндэрсэн шалтгаанаар одоо болтол гүйцэтгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана”, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ”, 351.1-т “Захиалагч дараахь үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажлаагүй байна. (Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэв)

-Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/243 дугаар захирамжаар “Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгэх тухай” эрх шилжүүлснээр “Халуун усны барилгад дулаан, цэвэр усны шугам татах” ажил гүйцэтгэхээр 2023 оны 08 дугаар сарын 28-ны 05 дугаар гэрээг Засаг дарга Д.Пүрэвсүрэн Би Би Ди Эм ХХК-ний захирал Ж.Мөнхсайхан нар байгуулсан байна. Уг гэрээний 2.4-т ажил дуусах хугацаа 2023 оны 09 дүгээр сарын 28-нд дуусах, 5.1-т “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ” хэрэгжүүлээгүй, санхүүжилт урьдчилгаа 40,000,000 төгрөг олгосон, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс 45,000,000 төгрөгийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэл дутуу учраас буцаан татсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана”, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ”, 351.1-т

“Захиалагч дараахь үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажлаагүй байна. (Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэв)

-Малын тоо толгойн албан татварын 2023 оны эцсийн байдлаар нийт 411 мал бүхий иргэний татвар төвлөрүүлэлт 2022 оны үлдэгдэл 18 иргэний 795,200 төгрөг, 2023 оны үлдэгдэл 25 иргэний 1,424,400 төгрөгийн авлага буюу дутуу төвлөрүүлээгүй нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ноогдуулна”, 5.2-т “Тухайн татварын жилд албан татвар ноогдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

7. ДҮГНЭЛТ

1. Шалгалтаар Баянбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд 47,920,000 төгрөгийн зөрчил, Засаг даргын Тамгын газрын 2022, 2023 оны үйл ажиллагаатай холбоотой Засаг даргын нөөц 10,011,990 төгрөг үйл ажиллагаа 54,791,182 нийт 112,723,172 төгрөгийн зөрчил илэрч байгаа нь нийт төсвийн гүйцэтгэлийн 6,1%-ийг эзэлж байна. Хяналт шалгалтаар 3,366,990 төгрөгийн улсын ахлах байцаагчийн төлбөрийн акт тогтоож, 67,920,000 төгрөгийн Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 41,436,182 төгрөгт зөвлөмж мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

2. Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль эрхзүйн мэдлэг дутмаг, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хөтлөх явцдаа дээрх зөрчлүүдийг гаргасан.

3. Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулалтад хяналт сул, Засаг дарга өөрөө өөртөө давуу байдлыг бий болгож нийт 10,011,990 төгрөгийг зөрчилтэй зарцуулахдаа анхан шатны баримтгүй 3,366,990 төгрөг, Засаг даргын шийдвэргүй 2,145,000 төгрөгийн хөрөнгө мөнгийг зарцуулсан.

4. Жолоочийн замын хуудасгүй 884,390 төгрөгийн шатахуун зарцуулсан.

5. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга Дотоод хяналт шалгалтын нэгж байгуулсан ч тус нэгж нь дотоод хяналт шаглалтыг зохион байгуулаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг мөрдлөг болгож ажиллаагүй.

6. Иргэн, аж ахуй нэгжээр гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэхдээ ажлын үр дүнг тооцдоггүй, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, ажлын гүйцэтгэлгүй байхад санхүүжилтийг 100% шилжүүлдэг.

Өвс тэжээл, тусламжийн бараа материалын үнэгүй олгох, хөнгөлөлттэй үнээр борлуулах эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийн хуваарийн дагуу тухай бүр тайлан тооцоог бодож хэвшихийг анхаарах хэрэгтэй байна.

Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

Хяналт шалгалт хийсэн тухай тайланг албаны дарга болон аудитын хорооны хуралд танилцуулж, дүнг байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
 АХЛАХ БАЙЦААГЧ Л.ЖАРГАЛЦЭЦЭГ
 ДОТООД АУДИТОР О.БЯМБАСҮРЭН

ТАНИЛЦСАН:
 ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВСҮРЭН
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНД-АЮУШ
 НЯГТЛАН БОДОГЧ Б.ЧИМЭДЦЭЕЭ
 НЯРАВ Ч.ЧУЛУУНБАТ





БАЯНХОНГОР АЙМАГ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 11/19-03/02

Номгон

Г Засаг даргын Тамгын газрын эко нойл
барих ажлыг бүрэн гүйцэтгүүлэх тухай

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан 07/05 тоот удирдамжийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь "Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх", 8.2.3 дахь "сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна" гэсэн заалт, Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар(РД:9008551) 2022, 2023 оны санхүүгийн баримтанд хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Жаргалцэцэг, Дотоод аудитор О.Бямбасүрэн нар 2024 оны 04 дүгээр сарын 05-аас 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар: Баянбулаг сумын Засаг дарга Д.Пүрэвсүрэн, Баянбулаг сумын 2 дугаар багийн М.Бат-Очир нарын хооронд байгуулсан "Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар эко оо барих" ажлын гэрээний дагуу тус ажил 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр бүрэн хүлээлгэж өгөхөөр гэрээнд тусгагдсан байтал тухайн ажил хийгдээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байхад Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн "Эко ариун цэврийн байгууламжийн тухай" А/41 дүгээр тушаалаар 20,000,000 төгрөгийн санхүүжилтийг 100 хувь шилжүүлсэн.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана" Иргэний

642211038

хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 350 дугаар зүйлийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ”, 351.1-т “Захиалагч дараахь үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Монгол Улсын Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1.Засаг даргын Тамгын газрын Эко нойл барих ажлыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийлгэж гүйцэтгүүлсүгэй.

2.Гүйцэтгэсэн ажлын тайланг ажил хүлээлцсэн актын хамт албан бичгээр, нотлох баримттай ирүүлэх.

Албан шаардлагыг биелүүлээгүй, хариуг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг анхааруулж байна.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ Л.ЖАРГАЛЦЭЦЭГ
ДОТООД АУДИТОР О.БЯМБАСҮРЭН

ХҮЛЭЭН АВСАН
ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВСҮРЭН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНД-АЮУШ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ Б.ЧИМЭДЦЭЭЭ
ГҮЙЦЭТГЭГЧ М.БАТ-ОЧИР



БАЯНХОНГОР АЙМАГ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 09/19-03/

Номгон

Г Засаг даргын нөөц хөрөнгөнөөс анхан шатны баримтгүй зарцуулсан хөрөнгө мөнгө төлүүлэх тухай Г

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан 07/05 тоот удирдамжийн дагуу дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь зүйл, 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсгийн заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь "Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх", 8.2.3 дахь "сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт"-д заасан бүрэн эрхийн хүрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд Баянбулаг сумын Бүрд 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших Засаг даргын Тамгын газар(РД:9008551) 2022, 2023 оны санхүүгийн баримтанд хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Жаргалцэцэг, Дотоод Аудитор О.Бямбасүрэн нар 2024 оны 04 дүгээр сарын 05-аас 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар: Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/88 дугаар захирамжаар нутгийн зөвлөлийн уулзалт хэлэлцүүлэгт 5,440,000 төгрөг зарцуулахдаа 3,366,990 төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх",

642409024

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар” Сангийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3-т “Нөөц хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргахад тавигдах шаардлага” 3.1.4-т “арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг зөв, бодитой тооцсон эсэхийг холбогдох норм, норматив, тариф, бусад баримтаар нотолсон байх”, 5-т “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, зардлыг санхүүжүүлэх”, 5.2-т “Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2-т “аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.5-т “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ” гэснийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 3,366,990 төгрөгийг Баянбулаг сумын Засаг дарга Д.Пүрэвсүрэн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Цэнд-Аюуш, ерөнхий нягтлан бодогч Б.Чимэдцээ нараар хувь тэнцүүлэн төлүүлж, Төрийн сангийн хүү торгуулийн орлогын **100030000982** (РД:9036001) тоот дансанд 2024 оны 07 дугаар сарын 31-ний дотор төвлөрүүлэхийг Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Цэнд-Аюуш, ерөнхий нягтлан бодогч Б.Чимэдцээ нарт хариуцуулсугай.

2. Хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй, илэрсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д заасны дагуу хариуцлага хүлээлгэсүгэй.

3. Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Цэнд-Аюуш, ерөнхий нягтлан бодогч Б.Чимэдцээ нар нь 19-03/..... тоот актыг 2024 оны 04 дүгээр сарын 17-

ны өдөр хүлээн авсан бөгөөд 668,095 төгрөгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй, хохирлыг холбогдох этгээдээр төлүүлээгүй тохиолдолд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Баянхонгор аймгийн Шүүхэд хүсэлт, нэхэмжлэлийг гаргаж шийдвэрлүүлэхийг танилцуулсугай.

4. Та Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана" гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 11.1-д заасны дагуу гомдол гаргахыг танилцуулсугай.

БИЧСЭН
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
 АХЛАХ БАЙЦААГЧ Д.ЖАРГАЛЦЭЦЭГ
 ДОТООД АУДИТОР *[Signature]* О.БЯМБАСҮРЭН

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
 ЗАСАГ ДАРГА *[Signature]* Д.ПҮРЭВСҮРЭН
 РЕГИСТРИЙН ДУГААР *31174010611*
 ГЭРИЙН ХАЯГ *Баянхонгор сум 12 баг*
 ОГНОО: *2024.04.17* ХУГАЦАА:
 УТАС: *88508832*

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДАРГА *[Signature]* Д.ЦЭНД-АЮУШ
 РЕГИСТРИЙН ДУГААР *ВН71107407*
 ГЭРИЙН ХАЯГ *Баянхонгор сум 12 баг*
 ОГНОО: *2024.04.17* ХУГАЦАА:
 УТАС: *88294045*

ЕРӨНХИЙ НЯГТЛАН
 БОДОГЧ *[Signature]* Б.ЧИМЭДЦЭЭ
 РЕГИСТРИЙН ДУГААР: *ВН7111501*
 ГЭРИЙН ХАЯГ *Баянхонгор сум 7-р баг*
 ОГНОО: *2024.04.18* ХУГАЦАА: *10:42*
 УТАС: *88588551*



БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 12/18

Номгон

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан 07/05 дугаар удирдамжийн дагуу Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 05-аас 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийг дуусталх хугацаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Дотоод хяналт шалгалтын дотоод журмыг боловсруулж, хяналт шалгалт хийх тухай бүрт удирдамж гаргаж Засгийн Газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-н өдөр баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3-т "Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-т Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухай байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 2.3-т "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино", 3.7.1-т "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах" гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2. Авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллаж Төсвийн тухай хуулийн 4 зүйлийн 4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэх

3. Төсвийн хөрөнгийн эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж, төсвийн үр ашгийг дээшлүүлж Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох.

4. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг тухай бүр үнэн зөв

642312170

бөглөж, гүйцэтгэсэн ажлын тайланг харгалзан үзэж тооцоог шахан гүйлгээг хийж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

5.Эргэлтийн хөрөнгийн (тээвэр шатахуун) тооцоог тухай бүр бодож шатахуун зарцуулсан албан хаагчдаар замын хуудсыг Санхүү, эдийн засгийн сайд, үндэсний статистикийн газрын даргын хамтран баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4 дэх хэсэг "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэснийг мөрдөж, тус заавраар баталсан НХ-Маягт Т-4 "Жолоочийн тооцооны хуудас"-ыг хөтөлж хэвших.

6.Албан хаагчдын ажилласан жилийг тооцохдоо нотлох баримттай тулгалт хийж, төрд ажилласан жилийг "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо" цахим системд оруулахдаа хүний нөөц хариуцсан ажилтан ажилдаа үнэн зөв оруулж, байгууллагын дарга хяналт тавьж ажиллах.

7.Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах.

8.Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж хөрөнгийн хадгалалт хамгаалалтад байнга хяналт тавих.

9.Өвсний тооцоог сар бүр хийж тайланг үнэн зөв гарган нягтлан бодогч тооцоо бодолтыг хийж, байгууллагын даргаар хянуулан дараагийн гүйлгээг хийдэг байдлыг хэвшил болгож ажиллах.

10.Улсын ахлах байцаагчийн тогтоосон төлбөрийн акт 3,366,990 төгрөгийг хугацаанд нь барагдуулж өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах.

Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хугацаанд биелүүлж хариуг 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Цэнд-Аюуш, нягтлан бодогч Б.Чимэдцэеэ нарт хариуцуулав.

Зөвлөмжийг биелүүлж хариу ирүүлээгүй тохиолдолд Дотоод аудитын дүрэмд заасан арга хэмжээ авч ажиллахыг анхааруулсугай.

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
ДОТООД АУДИТОР



О.БЯМБАСҮРЭН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА

306 дугаар байр, Харзны-3 гудамж,
Бүрд 4 дүгээр баг, Баянбулаг сум,
Баянхонгор аймаг, 64265 Утас:88294045
Цахим шуудан: info@bayanbulag.bkh.gov.mn

2024.08.16 № 94

танай 2024.04.17-ны № 09/19-03/-т

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН Г
ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНД

Тус байгууллагын 2022-2023 оны төсвийн
хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт
хийж өгсөн акт, албан шаардлагын хэрэгжилтийг
хүргүүлж байна.

Хавсралт... хуудастай



ДАРГА Д. ПҮРЭВСҮРЭН

642405077

БАЯНХОНГОР АЙМАГ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОДООД АУДИТЫН
ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ

2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр

Бүрд

Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/88 дугаар захирамжаар нутгийн зөвлөлийн уулзалт хэлэлцүүлэгт 5,440,000 төгрөг зарцуулахдаа 3,366,990 төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан гэж Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Улсын ахлах байцаагчийн тогтоосон актын төлбөрийг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр төлж барагдуулсан.

Засаг даргын тамгын газрын “Эко ариун цэврийн байгууламж” барих ажлыг бүрэн хэрэгжүүлэх тухай албан шаардлага өгснийг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг хүлээн авч ажил хүлээлцэх акт болон бодит зургаар баталгаажуулан холбогдох баримтыг хавсарган хүргүүлж байна.

Биелэлт гаргасан

Нягтлан бодогч *Б.Чимэдцэвэр* Б.Чимэдцэвэр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 7089693

Гүйлгээний дугаар /PoId: 0

Системийн огноо/System Date: 2024-08-16

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5227003178	ХАТАГТАЙ ЧОГЧИНДОРЖ ЧУЛУУНБАТ	3,386,990.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No MOFUMNUB	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	3,386,990.00 MNT	1.00
	100030000982	Бх.МХГазар - орлого		

Гүйлгээний утга/Transaction description:

БАЯНБУЛАГ ЗДТГ АКТИЙН ТӨЛБӨР

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



Овог, нэр/FullName: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat

Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer

Баталгаажуулах код/Verification code:

J6OYP1097M9EH7L1

Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орлох чадамжтай тоон гарын үсгээр баталгаажсан болно.

This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.

Ta <https://verify.khanbank.com/> вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

You can verify this document by going to <https://verify.khanbank.com/> and entering the 16-digit verification code provided. You can also find more information about digital signature on this page.

Санамж: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу

ТАМГА ТЭМДЭГ

Эрүүл мэндийн төвийн 1суултууртай, 1шээлтүүртэй,1 энгийн суултууртай эко нойл



Засаг даргын тамгын газарт 1суултууртай, 1шээлтүүртэй,1 энгийн суултууртай эко нойл

